

## НИЙГМИЙН УХААНЫ ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН СЭДВИЙН ХҮРЭЭНД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

### ТҮҮХ, НИЙГЭМ, ГАЗАРЗҮЙН БОЛОВСРОЛ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШИЙН ХӨГЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ОЮУНБИЛИГ

Нийгмийн ухааны хичээлээр нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн төгсөх 12 дугаар ангийн 3589 сурагч шалгуулсан. “Амжилтын гараа-3” уралдааны нийгмийн хичээлийн шалгалт нь 6 бүлгийн 56 сонгох, харгалзуулах 4 даалгавартай бөгөөд онооны хувьд харилцан адилгүй байна. Даалгавар тус бүр 1-2 оноотой байгаа нь даалгаврын бүтэц, хэлбэрээс хамааралтай. Харгалзуулах даалгаврын хувьд нийгмийн давхраажилт, соёл, эдийн засаг, улс төр бүлэг сэдвийн хүрээнд задгай 4 даалгавартай ба даалгавар тус бүр 6 оноотой, нийт 24 оноотой байна.

Сонгох даалгаврын агуулгын хувьд:

- 1-9 дүгээр даалгавар нийгмийн ойлголт, нийгмийн давхраажилт
- 10-17 дугаар даалгавар соёл
- 18-27 дугаар даалгавар эдийн засгийн онол
- 28-43 дугаар даалгавар улс төрийн шинжлэх ухаан
- 43-46 эдийн засгийн онол
- 47-56 дугаар даалгавар олон улсын харилцааны үндэс гэсэн бүтэцтэй байна.

Нийт даалгавар гүйцэтгэсэн сурагчдын тоог гүйцэтгэлээр үзүүлбэл: А болон С хувилбарын даалгавар гүйцэтгэсэн нийт 1795 сурагчаас 49 оноотой 1 сурагч, 48-1, 46-1, 45-0, 44-7, 43-5, 42-7, 41-6, 40-11, 39-21, 38-22, 37-33, 36-34, 35-38, 34-37, 33-41, 32-56, 31-61, 30-72, 29-65, 28-106, 27-103, 26-104, 25-101, 24-105, 23-103, 22-98, 21-88, 20-67, 19-68, 18-58, 17-65, 16-55, 15-33, 14-27, 13-23, 12-26, 11-9, 10-10, 9-13, 8-4, 7-5, 6-0, 5-1, 4-0, 3-2, 2 оноотой 1 сурагч тус тус шалгагдсан байна. Дээрх үзүүлэлтээс харахад дундаж оноо нь 25 байгаа бөгөөд авбал зохих 56 онооноос хамгийн өндөр 49 оноог 1 хүүхэд авсан бөгөөд хэмжээст оноо нь /T score/ 83,5 байна. Шалгалтын тестийн хэвийн тархалтын графиктай анхны онооны тархалтын муруйг харьцуулж харахад тархалтын орой нь дундаж гүйцэтгэлтэй хэсэгт /41-50 хувь/ шилжилттэй гарсан байна. Сонгох даалгаврын хувьд 12, 3, 15, 21, 48, 17, 22, 53, 35, 13, 16, 41, 1, 40, 25, 36, 8, 9 дүгээр даалгавруудыг сурагчид 86,6%, 83,2%, 78,4%, 77,4%, 72,3%, 70,8%, 69,1%, 64,5%, 62%, 60,3%, 58,5%, 57%, 56,2%, 52,3%, 52,2%, 52,1%, 51,1%, 50% зэрэг өндөр хувьтай гүйцэтгэсэн ба дундаж гүйцэтгэл нь 64,1%-тай байна. Эдгээр даалгавруудыг дүгнэн үзэхэд даалгаврын хувьд хүндрэлийн зэрэг ихтэй боловч гүйцэтгэл өндөртэй даалгавар гэж үзэж байна. Харин 55,10,7,34,43,56,42 дугаар даалгаврууд гүйцэтгэлийн дундаж хувь 15,6% байгаагаас үзэхэд дээрх даалгавруудын агуулгад анхаарах шаардлагатай.

File Edit Format View Help													
5	+	247	13.8	+	123	25.4	+	30	6.2	+	19.2	28.7	+
6		2	.1		0	.0		1	.2		-.2	21.5	
7		114	6.4		14	2.9		59	12.2		-9.3	20.1	
DATE 01/06/** National Research Centers of the IEA TESTAN 6													
MULTIPLE CHOICE ITEMS SORTED BY DIFFICULTY				Order	MULTIPLE CHOICE ITEMS SORTED BY DISCRIMINATION				Order	MULTIPLE CHOICE ITEM: BY ITEM-TOTAL CORREI			
Discrimination	Item	Difficulty			Discrimination	Item	Difficulty			Correlation	Item	Di	
19.8	14	91.4		1	57.3								
35	62.0	1		.462	35	62.0							
32.4	12	86.9		2	52.2	36	52.1		2	.433	21		
22.5	3	83.2		3	49.7	54	45.7		3	.415	36		
35.9	15	78.4		4	47.6	25	52.3		4	.407	12		
45.8	21	77.4		5	46.6	51	35.8		5	.387	54		
40.6	48	72.3		6	45.8	21	77.4		6	.383	51		
44.1	17	70.8		7	45.6	29	38.0		7	.379	17		
40.0	22	69.1		8	45.2	38	43.3		8	.379	29		
42.5	53	64.5		9	44.1	17	70.8		9	.375	38		
57.3	35	62.0		10	43.9	45	42.2		10	.369	45		
41.6	13	60.3		11	43.9	9	50.0		11	.369	25		
38.6	16	58.5		12	42.5	53	64.5		12	.360	53		
35.3	41	57.0		13	42.5	39	44.3		13	.355	9		
33.2	1	56.2		14	41.6	13	60.3		14	.354	15		
41.0	40	52.3		15	41.4	32	35.0		15	.352	22		
47.6	25	52.3		16	41.2	8	51.1		16	.350	48		
52.2	36	52.1		17	41.0	49	42.9		17	.350	39		
41.2	8	51.1		18	41.0	40	52.3		18	.331	32		
43.9	9	50.0		19	40.8	26	49.6		19	.330	8		
40.8	26	49.6		20	40.6	48	72.3		20	.328	49		
28.5	18	49.2		21	40.0	22	69.1		21	.322	40		
33.6	4	49.1		22	39.0	50	42.8		22	.321	13		
33.0	2	48.1		23	38.6	16	58.5		23	.321	50		
37.5	46	47.8		24	37.5	46	47.8		24	.318	26		
49.7	54	45.7		25	35.9	15	78.4		25	.315	16		
42.5	39	44.5		26	33.2	41	57.0		26	.303	34		
1.4	37	44.1		27	33.2	4	49.1		27	.301	14		
45.2	38	43.3		28	33.2	1	56.2		28	.297	46		
41.0	49	42.9		29	33.0	2	48.1		29	.296	6		
39.0	50	42.8		30	32.4	12	86.9		30	.285	41		
43.9	45	42.2		31	31.5	6	35.8		31	.283	1		
28.5	47	41.7		32	31.3	31	26.8		32	.283	2		
28.0	23	40.6		33	29.1	19	40.3		33	.281	4		
29.1	19	40.3		34	28.9	5	33.6		34	.270	31		
20.6	11	40.0		35	28.5	47	41.7		35	.256	5		
45.6	29	38.0		36	28.5	18	49.2		36	.255	19		
46.6	51	35.8		37	28.0	23	40.6		37	.252	33		
31.5	6	35.8		38	27.6	33	30.6		38	.249	3		
41.4	32	35.0		39	26.2	24	34.8		39	.244	47		
26.2	24	34.8		40	26.2	34	16.3		40	.237	23		
28.9	5	33.6		41	22.5	3	83.2		41	.221	18		
27.6	33	30.6		42	22.1	27	26.1		42	.216	52		
18.6	44	30.4		43	21.2	52	24.6		43	.214	24		
2.9	28	29.4		44	20.6	30	28.2		44	.205	30		
20.6	30	28.2		45	20.6	11	40.0		45	.205	56		
31.3	31	26.8		46	19.8	14	91.4		46	.187	11		
22.1	27	26.1		47	19.2	56	13.8		47	.179	27		
21.2	52	24.6		48	18.6	44	30.4		48	.174	7		
10.9	20	24.1		49	15.3	7	17.7		49	.173	44		
5.4	55	18.8		50	13.6	10	17.7		50	.166	10		
13.6	10	17.7		51	10.9	20	24.1		51	.165	42		
15.3	7	17.7		52	10.3	42	11.0		52	.134	20		
25.6	34	16.3		53	9.4	55	18.8		53	.065	55		
-4.1	43	13.9		54	2.9	28	29.4		54	.045	37		
19.2	56	13.8		55	-1.4	37	44.1		55	-.033	28		
10.3	42	11.0		56	-4.1	43	13.9		56	-.038	43		
DATE 01/06/** National Research Centers of the IEA TESTAN 6													
RELIABILITY ESTIMATES													
Mean percent correct (difficulty) 44.6				Horst modified formula 20 .792				Items needed for .900 reliabi					
				Kuder-Richardson formula 20 .784				Chance estimate from 56 ite					

Даалгаврын бүтцийн хувьд багш сурагчид тус сорилын 11, 27, 7, 44, 10, 42, 20, 55, 37, 28, 43 дугаар даалгаврыг гүйцэтгэхэд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

**Сурагчдын даалгавар хийж гүйцэтгэсэн байдалд дүгнэлт хийж, багш нарт зөвлөмжлөх нь:**

1. Багш сурагчид эдийн засгийн онол, улс төрийн шинжлэх ухаан гэсэн айн хүрээнд анхаарч ажиллах хэрэгтэй гэж үзэж байна. Иймд нийгмийн ухааны хичээл зааж байгаа багш нар энэ агуулгаар сурагчдын шинжлэх ухааны болон мэдээлэл, эх сурвалж, кейс ажиллах, судалгаа шинжилгээний мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох ном сурах бичгийг судлах шаардлагатай.

2. Эдийн засаг онол айн хүрээнд:

- Микро болон макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн мөн чанарыг ойлгож, тооцоолол хийж сурах
- ААН-ийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийг тооцох, зах зээлийн эрэлт нийлүүлэлт, үнийн хамаарлыг тогтоох, график дээр ажиллах чадвар эзэмшүүлэх,
- Төрийн макро эдийн засгийн бодлого, эдийн засгийн гадаад бодлогын мөн чанар, зорилгыг тайлбарлах

- Монгол улсын гадаад худалдааны алдагдлыг бууруулах, эх орны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд гаргах боломжийг илрүүлж, тооцоолол гаргах чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах

3. Улс төрийн шинжлэх ухаан айн хүрээнд:

- Улс төрийн онолын хандлага, урсгалуудыг харьцуулан судлах замаар улс төрийн шинжлэх ухааны үүсэл хөгжил, үндсэн ойлголт, зарчмууд, тэдгээрийн уялдаа холбооны талаар мэдлэг олгох
- Улс төрийн шинжлэх ухааны судлагдахууны онцлогийг таниулах
- Улс төрийн үзэгдэл үйл явцыг судлах анхан шатны ур чадвар эзэмшүүлэх
- Улс төрийн амьдралд оролцох иргэний суурь чадамжуудад суралцуулахад анхаарах

4. Сурагчдыг ЭЕШ-д бэлтгэх, суралцагчдад тест ажиллах чадвар олгох, даалгавар хийж гүйцэтгэх явцад тааж хийхгүй байхыг анхаарах

5. Нийгмийн ухааны хичээлийн 12 дугаар ангийн цөм хөтөлбөрийн агуулгад “Социологи”, “Логик” гэсэн агуулга орсон тул эдгээр агуулгыг сурагчдад сайн ойлгуулах шаардлагатай байна.